



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 677

Улаанбаатар хот

Хөрөнгө эзэмшигч, ашиглагчийг тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газар Америкийн Нэгдсэн Улсын Мянганы сорилтын корпораци хооронд байгуулсан Монгол Улсын Олон улсын гэрээ болох II Компакт гэрээний дагуу Улаанбаатар хотын нийт усан хангамжийг нэмэгдүүлэх цогц хөтөлбөрийн “Усан хангамжийн баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төсөл” болон “Хаягдал ус дахин боловсруулах төсөл”-ийн хүрээнд бий болсон хөрөнгийг эзэмших, ашиглах төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. “Дулааны IV цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ү.Төмөрхуяг, “Дулааны III цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал К.Эрдэнэбаяр, “Ус сувгийн удирдах газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга Ц.Төрхүү, нийслэлийн “Сонгинохайрхан Дэд бүтэц хөгжлийн алба” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга Ж.Мөнхзориг, Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга В.Оюумаа нарт дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Монголын Мянганы сорилтын сантай хамтран хүний нөөцийг чадавхжуулах сургалт болон туршилт, зүгшрүүлэлтийн ажлыг хийж төслийн хөрөнгийн эзэмшил, ашиглалтад хяналт тавих, хүлээн авах ажлыг зохион байгуулах;

2.2. Хүлээн авах хөрөнгөтэй холбоотой үйл ажиллагааны болон бусад холбогдох зардлыг төсөв, төлөвлөгөөнд тусгах арга хэмжээ авах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2026 оны 2 дугаар улирал хүртэл улирал тутам тайлагнаж байх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132003018


29-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 14 дугаар сарын 14-ны өдрийн
677 дугаар тогтоолын хавсралт

КОМПАКТ II ХӨТӨЛБӨРӨӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ГАЗРЫН ДООРХ УСНЫ БАРУУН ЭХ ҮҮСВЭРИЙГ
ШИНЭЭР БАЙГУУЛАХ ТӨСӨЛ БОЛОН ХАЯГДАЛ УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ТӨСЛИЙН БАРИЛГА
БАЙГУУЛАМЖ, ХОБОГДОХ ДЭД БҮТЭЦ, ТЭДГЭЭРИЙН ЭЗЭМШИГЧ, АШИГЛАГЧИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгө (барилга байгууламж, дэд бүтэц)-ийн нэр	Тоо хэмжээ	Нийт тоо хэмжээ	Эзэмших, ашиглах хуулийн этгээдийн нэр
А "Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах төсөл"-ийн хүрээнд бий болсон хөрөнгө:				
1	Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр	1	1 иж бүрдэл	"Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ
2	Шувуун эх үүсвэрийн худгийн барилга	16 худаг		
3	Биокомбинатын эх үүсвэрийн худгийн барилга	14 худаг	30 худаг	
4	Цуглуулах, дамжуулах шугам хоолой (Ф300мм-900мм)	56.4км	56.4 км	
5	Шувууны эх үүсвэрийн 10 кВ-ын агаарын шугам	9.1км		"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компани
6	Биокомбинатын эх үүсвэрийн 10 кВ-ын агаарын шугам	11км	20.1км	
7	10 кВ-ын хаалттай хуваарилах байгууламж	1		
8	Хатуу хучилттай асфальтан зам	2.4км	2.4км	Нийслэл, СХД Дэд бүтэц хөгжлийн алба ОНӨААТҮГ



Д/д	Хөрөнгө (барилга байгууламж, дэд бүтэц)-ийн нэр	Тоо хэмжээ	Нийт тоо хэмжээ	Эзэмших, ашиглах хуулийн этгээдийн нэр
Б. "Хаягдал ус дахин боловсруулах төсөл" -ийн хүрээнд бий болсон хөрөнгө:				
9	Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр	1	1 иж бүрдэл	Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ
10	Дахин боловсруулсан ус дамжуулах систем (Үйлдвэрээс Өргөлтийн насос станц хүртэлх шугам)	DN 1000 – 4.5 км	8.12 км	
		DN 700 – 3.62 км		
11	ДЦС-3 техникийн усны системийн шинэчлэлийн ажил	1	1 иж бүрдэл	"Дулааны III цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компани
12	Өргөлтийн насос станц	1	1 иж бүрдэл	
13	Дахин боловсруулсан ус дамжуулах систем (Өргөлтийн насосны станцаас ДЦС-3 хүртэлх шугам)		2.03 км	
14	ДЦС-4 техникийн усны системийн шинэчлэлийн ажил	1	1 иж бүрдэл	"Дулааны IV цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компани
15	Лабораторийн барилга	1	1 иж бүрдэл	
16	Дахин боловсруулсан ус дамжуулах систем (Салаалах худгаас ДЦС-4 хүртэлх 78 м шугам)	1	1 иж бүрдэл	
17	Үйлдвэрийн гадна 10 кВ-ын цахилгааны кабель шугам (Цэвэрлэх дэд станцаас үйлдвэр хүртэлх) 2*(3х240мм2)	2.2 км	2.2 км	"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компани
18	Үйлдвэрийн гадна 10 кВ-ын хаалттай дэд өртөө	1	1 иж бүрдэл	